



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А1142

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албан зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 06/463 тоот албан бичгээр ирүүлсэн "Зөвшөөрөл олгох тухай" 45 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, нийслэлийн Боловсролын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.


САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН



14241 0442

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2024 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн
Анх дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Боловсролын ерөнхий хууль

Дагаж мөрдөх огноо:

2023.08.03.

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Газрын дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-4

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Орон нутгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын байршил

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Боловсрол, шинжлэх ухааны салбарын болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үр дүнг Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө хариуцна.



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:

Боловсролын ерөнхий хууль

Дагаж мөрдөх огноо:

2023.08.03.

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны
газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Газрын дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-4

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Орон нутгийн Боловсрол, шинжлэх ухааны
газрын байршил

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Боловсрол, шинжлэх ухааны салбарын болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үр дүнг Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө хариуцна.


Албан тушаалын зорилт:

- 1.Боловсролын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих;
- 2.Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих;
- 3.Төсвийн шууд захирагчийн хувьд байгууллагын төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулах, тайлагнах;
- 4.Байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.


Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Боловсролын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;	Хууль тогтоомж хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г, Х
	2.Хичээл, судлагдахууны агуулга, арга зүй, үнэлгээ, технологи болон зайн, цахим сургалтыг хөгжүүлэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;	Чанартай боловсрол эзэмших, тэгш боломж бүрдсэн байна.	Г, Х
	3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.6, 7.7-д заасан зөвшөөрөл олгох эсэх талаар санал, дүгнэлт гаргах;	Стандартын шаардлага хангасан байгууллага нэмэгдэнэ.	Г, Х
	4.Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх;	Байгууллагын үйл ажиллагаа сайжирсан байна.	Г, Х
	5.Өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах;	Сургалтын байгууллагын менежмент сайжирсан байна.	Г, Х
	6.Иргэнд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах, насан туршдаа суралцахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;	Тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлсэн байна.	Г, Ш



<p>7.Өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад хоол хүнсний хангамж, сургалтын орчны аюулгүй байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тохирох орчныг бүрдүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;</p>	<p>Сургалтын эрүүл аюулгүй орчин нөхцөл бүрдсэн байна.</p>	<p>Г, Ш</p>
<p>8.Сургуулийн орчинд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, боловсролын сургалтын байгууллагыг арга зүй, зохицуулалтаар хангах;</p>	<p>Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжсэн байна.</p>	<p>Г, Х</p>
<p>9.Орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын гамшгийн эрсдлийг үнэлэх, гамшгийн үед хариу арга хэмжээ авах, нөхцөл байдлыг тогтворжуулахад хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;</p>	<p>Гамшгийн үед ажиллах бэлэн байдал хангагдсан байна.</p>	<p>Г, Ш</p>
<p>10.Гамшгийн улмаас хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоох тохиолдолд боловсролын сургалтын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах;</p>	<p>Хичээл, сургалтын үйл ажиллагаа тасалдахгүй байна.</p>	<p>Г, Х, Ш</p>
<p>11.Орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан, албан хаагч ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;</p>	<p>Ёс зүйн болон аливаа зөрчил гарахгүй болно.</p>	<p>Г, Х</p>
<p>12.Орон нутгийн насан туршийн суралцахуйн төвтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;</p>	<p>Насан туршдаа суралцах боломж бүрдэнэ.</p>	<p>Г, Ш</p>
<p>13.Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн биелэлт, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих;</p>	<p>Хууль тогтоомж, стандартад нийцсэн байна.</p>	<p>Г, Х</p>
<p>14.Зайн болон цахим сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;</p>	<p>Зайн болон цахим сургалт зохион байгуулагдах боломж бүрдсэн байна.</p>	<p>Г, Х</p>




	15.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;	Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байна.	Г, Ш
	16.Хамран сургах тойргийг аргачлалын дагуу тогтоож, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах, хяналт тавих;	Хамран сургах тойрог мөрдөгдсөн байна.	Г, Х
	17.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх;	Хяналт шалгалт зохион байгуулагдсан байна.	Х, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1.Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;	Хууль тогтоомж хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г, Х
	2.Шинжлэх ухаан, технологи, инновацийн дэд бүтэц байгуулах, хөгжүүлэх асуудлаар хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;	Хууль тогтоомжид заагдсан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г, Х
	3.Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд "Шинжлэх ухаан, технологийн орон нутаг дахь салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой байдлыг хангах, Боловсрол, шинжлэх ухааны сайдын аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан ажлын хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд хангаж ажиллах;	Шинжлэх ухаан, технологийн орон нутаг дахь салбар зөвлөл"-ийн төлөвлөгөө, гэрээний биелэлт хангагдсан байна.	Г, Х
	4.Орон нутгийн иргэдийн санал санаачилгыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд гарааны санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах;	Дэмжлэг үзүүлсэн байна.	Г, Х
	5.Байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан, шинжлэх ухаан, технологийн үр дүнд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, зохион байгуулалт, зохицуулалтыг ханган хэрэгжүүлэх;	Бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болсон байна.	Г, Х



	6. Аймаг, орон нутаг, бүсийн түвшинд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагатай хамтран ажиллах;	Хамтын ажиллагаа тогтворжсон байна.	Г, Х
	7. Боловсролын сургалтын байгууллага болон ажил олгогч, шинжлэх ухааны байгууллагын хамтын ажиллагаа, уялдааг хангах, түншлэлийг бий болгох, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	Хамтын ажиллагаа бэхжсэн байна.	Г, Х
	8. Шинжлэх ухаан, технологи, инновацийг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	Иргэд олон нийт шинжлэх ухаан, технологийн салбарын мэдээ, мэдээллийг тогтмол авсан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1. Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;	Төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн байна.	Г
	2. Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зориулалтын дагуу зарцуулах; зарцуулалтад нь хяналт тавих;	Төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	3. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг олгох;	Төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн байна.	Г, Ш
	4. Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;	Төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн байна.	Г
	5. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд	Төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны	Г, Х


	тайлагнах, Үндэсний аудитын газраар аудит хийлгэх;	дагуу хэрэгжүүлсэн байна.	
	6.Яам болон Боловсролын ерөнхий газар, Сангийн яамнаас шаардсан мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх;	Төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	7.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилтэд хяналт тавих, балансад байгаа өмч хөрөнгийг зохих журмын дагуу эзэмшиж, ашиглах	Төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн байна.	Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, тайлагнах, дүгнүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтууд хангагдсан байна.	Х, Ш
	2.Байгууллагын албан хаагчдыг өдөр тутмын удирдлага, зөвлөмж, арга зүйгээр хангах, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хяналт тавих, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх;	Байгууллагын болон мэргэжилтнүүдийн чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.	Г, Х
	3.Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх;	Хууль тогтоомж, стандартад нийцсэн байна.	Г, Ш
	4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;	Дүрэм, журмын хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	5.Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, стандартыг хэрэгжүүлэх, хяналт тавих;	Стандарт хангагдсан байна.	Х, Ш
	6.Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг судлан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;	Хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна.	Х, Ш
	7.Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж, сургаж чадавхжуулах ажлыг зохион байгуулах;	Сургалтын болон нийгмийн баталгаа хангах хөтөлбөр хэрэгжсэн байна.	Г, Х
	8.Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	Ил тод байдал бүрдсэн байна.	Г, Х, Ш



9.Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, хяналт тааих	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш
10.Жендэрийн тухай хуулийн хэрэгжүүлэх, хяналт тааих	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш
11.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх, тайлагнах	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш
12.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.	Г, Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	Боловсрол /011/.
Мэргэшил	- Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх; - Төрийн болон боловсролын удирдлага, төлөвлөлт, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ, нийгмийн ажил, сэтгэл зүйн аль нэг чиглэлээр сургалтад хамрагдаж төгссөн байх.
Туршлага	- Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх; - Боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан, эсхүл нийгмийн ажилтнаар 5-аас доошгүй жил ажилласан байх.
Удирдан зохион байгуулах	- байгууллагын алсын харааг тодорхойлох; - байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах; - байгууллагын үйл ажиллагаа дахь эрсдэлийг урьдчилан тодорхойлох, илрүүлэх, авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх; - албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих; - албан хаагчдын сургалт хөгжлийн асуудалд идэвхтэй дэмжлэг үзүүлж, тасралтгүй суралцагч байгууллага болох соёлыг төлөвшүүлэх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - албан хаагчдын ажил үүргийг оновчтой, тэнцвэртэй хуваарилах, адил тэгш хандах;

Ур чадвар		- бусад.
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - аливаа асуудлын талаар бүрэн ойлголт авахын тулд шаардлагатай мэдээллийг цуглуулах, үнэлэх, тайлбарлах; - хоорондоо шууд хамааралгүй нөхцөл байдлын байж болох уялдаа холбоог тодорхойлдог байх; - болзошгүй үр дагаврыг урьдчилан таамаглаж, үйл ажиллагааны боломжит хувилбарыг төлөвлөдөг байх; - мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа хийх; - судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлого, боловсруулах; - судалгааны дүн, шийдлийн хувилбарын шууд ба шууд бус үр дагаврыг харьцуулан үнэлж, зөвлөмж боловсруулах; - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр шуурхай гаргах; - асуудлыг хууль журам болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврыг тооцох; - аливаа асуудлыг шийдвэрлэхдээ хамт олны саналыг харгалзан үздэг байх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах - бусад.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх; - шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих, бүтээлч, санаачилгатай ажиллах; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - итгэлцлийг бий болгох, албан хаагчдад адил тэгш хандах, зөв шударгаар дүгнэх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтаар хамт олныг үлгэрлэн ажиллах; - нээлттэй, шударга байх; - бусад.
Бусад	<ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - кирилл болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх; - багаар ажиллах, багийн амжилтыг багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дүгнэх, нэгжийн хамт олонд таниулах; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - компьютерын хэрэглээний програм, мэдээллийн дээшилтэд техник, технологи ашиглах; 	



	<ul style="list-style-type: none"> - албан ажил чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах; - төрийн болон албаны нууц, хүний хувийн мэдээллийг хууль тогтоомжийн хүрээнд хадгалах, хамгаалах.
--	---

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Боловсрол, шинжлэх ухааны сайд

<p>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</p> <ul style="list-style-type: none"> - Хэлтсийн дарга - Албан хаагчид - Ерөнхий боловсролын сургуулийн захирал - Цэцэрлэгийн эрхлэгч 	<p>Бусад харилцах субъект:</p> <ul style="list-style-type: none"> - Яам, агентлагийн холбогдох албан тушаалтан; - Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан; - Төрийн болон төрийн бус байгууллага; - Иргэн, хуулийн этгээд.
--	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

<p>Албан тушаал:</p> <p>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА</p> <p><i>(Signature)</i></p> <p>..... (Б.ОТГОНЦЭЦЭГ)</p> <p>2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр</p>	<p>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</p> <p>Байгууллагын нэр:</p> <p>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ</p> <p>Шийдвэрийн огноо: 24 02 28</p> <p>Дугаар: 045</p>
--	--

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

<p>Байгууллагын нэр:</p> <p>БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ</p> <p>Шийдвэрийн огноо:</p> <p>Дугаар:</p> <p>(тамга/тэмдэг)</p>	<p>БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД (Л.ЭНХ-АМГАЛАН)</p> <p>2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр</p>
---	--



БҮРТГЭЛИЙН ДУГААР.....136.....
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
СТС2147 9116621
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2024 оны 04 сарын 02 ний өдөр